



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn



БАТЛАВ
ДАРГА Л.ЭРДЭНЭЧУЛУУН

2017.03.13 № 02-01/167
танай _____ -ны № _____ -т

Өргөх механизмын ашиглалтын
байдалд хяналт шалгалт хийх тухай

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны төлөвлөгөөний хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт-өргөх механизм ашиглагч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд "Төрийн хяналт шалгалтын тухай", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай", "Барилгын тухай", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай", "Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дүндэн өмчлөлын эд хөрөнгийн тухай" хууль, "Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Сагстай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Ачаа өргөх манипуляторт краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм" болон холбогдох бусад журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн сан үүсгэх, эрсдэлийн түвшинг тодорхойлж холбогдох арга хэмжээ авахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

1. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу шаардлагатай тохиолдолд бусад хэлтсүүд болон чиглэлүүдтэй хамтарсан байдлаар хийж гүйцэтгэнэ.

2. Хяналт шалгалтыг "Каркасан болон бүрэн цутгамал барилгын угсралтын ажлыг шалгах" 5.1.1 кодтой хяналтын хуудас, "Барилга, байгууламжийн ашиглалтыг шалгах" 5.2 кодтой хяналтын хуудас, "Өргөх механизм ашигладаг аж ахуйн нэгж

байгууллага, иргэнийг шалгах” 5.19.10 кодтой хяналтын хуудас, “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах” 4.1.2 кодтой хяналтын хуудсыг ашиглан шалгаж, эрсдэлийг тодорхойлох аргачлалаар зохион байгуулж ажиллана.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр

Нийслэлийн нутаг дэвсгэрт өргөх механизмын угсралт, засвар үйлчилгээ, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана. /шалгалтанд хамрагдах байгууллагуудыг 1-р хүснэгтэнд хавсаргав/

1. Холбогдох хуулиуд болон норм, дүрэм, журам, стандарт, зааврын мөрдөлт, хэрэгжилтийн байдлыг шалгах. Үүнд

2. “Өргөх механизм ашигладаг аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг шалгах” 5.19.10 кодтой хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлнэ.

а. Паспорт бичиг баримтын бүрдэл, улсын бүртгэл, ашиглах зөвшөөрөлтэй эсэх

б. Өргөх механизмыг угсрах, засвар үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэх

в. Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай угсралт, засвар үйлчилгээний гэрээ байгуулласан эсэх

г. Тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалтын байдал

д. Өргөх механизмын үзлэг техникийн нөхцөл

е. Техникийн магадлал хийлгэж тэнцсэн эсэх

ё. Ашиглалт хариуцагч, бүрэн бүтэн байдлыг хариуцагч, ачаа шилжүүлэх үеийн аюулгүй хариуцагч, мэргэжлийн операторчин, оосорлогч дохиочин, лифтчинтэй эсэх, тэдгээр нь мэргэжлийн мэдлэгийн давтан шалгалтанд хамрагдсан эсэх

ж. Өргөх байгууламжийн зориулалт, зураг төслийн баталгаажилт, мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй эсэх

з. Өргөх механизмын дүрмийн дагуу ашиглалт, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, техникийн болон засвар үйлчилгээний байдлыг тогтмол хөтөлж байгаа эсэхийг тус тус шалгана.

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч

Шалгалтыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн дарга Н.Гантулга, хэлтсийн ахлах А.Цэцэгмаа нар өдөр тутмын удирдлагаар хангаж Барилгын техникийн хяналтын улсын ахлал байцаагч П.Дашдаваа ахлаж, улсын ахлах байцаагч Г.Эрдэнэхүү, улсын байцаагч О.Сүнжидмаа нар хийж гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд холбогдох бусад чиглэлийн улсын /ахлах/ байцаагчдыг татан оролцуулна. /Улсын байцаагчдын нэрс, холбоо барих утасны жагсаалтыг хавсаргав./

Тав. Шалгалтын эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэж, хяналт шалгалтын дүнг ажлын 5 хоногт хэлтсийн даргад танилцуулна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрүүдэд хийнэ.

Зургаа. Өмнө хийсэн шалгалтын талаархи мэдээлэл

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас "Ачаа өргөх краныг шалгах" 5.19.1 кодтой хяналтын хуудас, "Эскалаторыг шалгах" 5.19.3 кодтой хяналтын хуудас, "Лифтийг шалгах" 5.19.4 кодтой хяналтын хуудас, "Барилгын өргүүр шалгах" 5.19.5 кодтой хяналтын хуудас, "Ачаа өргөгч манипуляторт краны шалгах" 5.19.6 кодтой хяналтын хуудас, "Өргөх механизм ашигладаг аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг шалгах" 5.19.10 кодтой хяналтын хуудсаар шалгахад их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 40 аж ахуйн нэгж, байгууллага болон 2017 онд шинээр баригдах барилга байгууламж, объектод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ.


Долоо. Шалгалтын дүн, авах арга хэмжээ

1. Шалгалтад хамрагдсан өргөх механизм эзэмшигч, ашиглагч байгууллагын өргөх механизмын техникийн байдалд дүгнэлт гаргах, илэрсэн зөрчлийг арилгуулах улсын /ахлах/ байцаагчийн эрх зүйн баримт бичгийг үйлдэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад хүргүүлэх бөгөөд улсын байцаагчийн эрхийн хүрээнд илэрсэн зөрчилд нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөөс гадна шалгагдсан өргөх механизмын жагсаалт, мэдээ тайланг хавсралт хүснэгтээр гаргана.


2. Шалгалтын дүн мэдээг сар бүрийн 20-ны дотор, нэгдсэн шалгалтын дүн мэдээ, танилцуулгыг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны дотор ажлын хэсгийн ахлагч нэгтгэн Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

3. Шалгалтын дүнгийн талаар МХЕГ-ын даргын 2010 оны 107 дугаар тушаалаар баталсан "Олон нийтэд мэдээлэл түгээх журам"-ийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

ТӨЛӨВЛӨСӨН:
ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА


И.ГАНТУЛГА

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ


Г.ЭРДЭНЭХҮҮ



